

## ХОВД АЙМГИЙН “АВАРГА” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл.

Манай аймаг спортын чөлөөт, жудо, волейбол, үндэсний бөх, хөнгөн атлетик, ширээний теннис гэх мэт төрлүүдээр бүс, улс, олон улсын тэмцээн уралдаануудад амжилт гаргаж байсан. Тухайлбал 1970-1990 онуудад волейболын спортоор улсад удаа дараа түрүүлж, Ховдын волейбол Монгол улсад тэргүүлж, чөлөөт бөхийн спортоор Ховд аймгийн тамирчид улсын шигшээ багийг бүрдүүлж, Монгол улсаа төлөөлөл олон улс, тив, дэлхий, олимпийн тэмцээнүүдэд оролцож байсан түүхтэй.

Сүүлийн жилүүдэд дээрх төрлүүдээр амжилт гаргах тамирчдын тоо цөөрч, алдартнуудын залгамж халаа буурах хандлагатай байна.

Иймд залуу шилдэг тамирчдыг төрүүлэн гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж аймгийн "Аварга" хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг боловсруулав.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго

2.1. Тамирчдын амжилтыг улс, тив, дэлхий, олимпийн түвшинд хүргэхэд дэмжлэг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

Гурав: Хөтөлбөрийн зорилт:

3.1. Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцлийг бүрдүүлж техник, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.2. Биеийн тамирын багш, дасгалжуулагч, баг тамирчдын ур чадвар, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцуулах.

3.3. Аймаг орон нутагт спортын сонгосон төрлүүд дээр тамирчид бэлтгэж улс, дэлхийн түвшинд өрсөлдөхүйц чадвар эзэмшүүлэх.

Дөрөв: Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

4.1 Зорилт 1-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1.1. Бэлтгэл сургуулилт хийх 5 заал, танхимыг тохижуулах.

4.1.2. Тамирчдын бэлтгэл сургуулилт хийх орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах.

4.2 Зорилт 2-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.2.1. Спортын сонгосон төрлүүдээр тэмцээн, уралдаан зохион байгуулах, оролцуулах

4.2.2. Багш, дасгалжуулагч, баг тамирчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургалт семинар зохион байгуулж холбогдох гарын авлага, материалаар хангах.

4.3. Зорилт 3-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.3.1. Тамирчдыг сорил, үзүүлэлтүүдийн дагуу сонгон шалгаруулах /багш дасгалжуулагч, тамирчдын эрүүл мэнд/

4.3.2. Үндэсний спортыг түшиглэн олимпийн төрөлд тамирчид бэлтгэж, тэднийг улс, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөхүйц чадвар эзэмшүүлэх /чөлөөт бөх, жүдо, бокс гэх мэт/

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа.

5.1. "Аварга" хөтөлбөрийг 2013-2016 он, 2016-2020 онуудад хэрэгжүүлнэ. 2013-2016 оны хооронд 3 үе шаттайгаар хэрэгжинэ.

- Нэгдүгээр шат: Хөтөлбөрийн хэрэгжилтийн бэлтгэл үе. 2013-2014 он. /Материаллаг бааз бүрдүүлэх, тамирчдын сонгон шалгаруулж бэлтгэлжилтийг эхлүүлэх/

- Хоёрдугаар шат: Бэлтгэл дасгалжуулалтын эрчимжих үе. 2014-2015 он. /бүс, улсын чанартай тэмцээнд оролцож амжилт гаргах/

- Гуравдугаар шат: Амжилт үр дүн гаргах үе. 2015-2016 он. /улс, олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнд оролцож амжилт гаргах/

2016-2020 онуудад амжилтууд өсөх үе.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

1. Биеийн тамир, спортыг дэмжих тусгай зориулалт бүхий сангийн хөрөнгө.
2. Орон нутгийн хөгжлийн сан.
3. Байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө.
4. Гадаад орон, олон улсын байгууллагуудын хандив, тусламж. .

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгө санхүү

№	Сонгогдсон спортын төрлүүд	Хөтөлбөр хэрэгжих хугацаа /жилийн нийт санхүүжилт 40 сая/				Тайлбар Бүгд Нийт дүн
		2013 он	2014 он	2015он	2016 он	
1	Үндэсний спортын төрөл <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний бөх</li> <li>• Үндэсний сур</li> </ul>	5%	40%	10%	10%	
2	Орон нутгийн топ төрөл <ul style="list-style-type: none"> <li>• Волейбол</li> <li>• Ширээний теннис</li> </ul>	5%	10%	25%	25%	
3	Олимпийн төрөл <ul style="list-style-type: none"> <li>• Жүдо бөх</li> <li>• Чөлөөт бөх</li> <li>• Бокс</li> </ul>	5%	10%	25%	25%	
4	Шинээр хөгжиж буй спортын төрөл <ul style="list-style-type: none"> <li>• Хөлбөмбөг</li> </ul>	5%	10%	20%	15%	
5	Багш дасгалжуулагч, тамирчдын эрүүл мэнд	5%	5%	5%	5%	
6	Спортын материаллаг бааз, сургалт, сурталчилгаа	75%	25%	15%	20%	
	Бүгд	100% 40 сая	100% 40 сая	100% 40 сая	100% 40 сая	160 сая

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт:

1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс хариуцна.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газар, сумдын Засаг даргын тамгын газар, Спортын холбоод олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтээр тооцно.

№	Шалгуур үзүүлэлт	2012	Хүрэх үр дүн
			2016
1	Спортын ордонд хичээллэж байгаа секц дугуйлангийн төрлийн тоо	10	15
2	Аймгийн шигшээ баг бүрдүүлэх секц дугуйланд хамрагдаж байгаа хүүхдийн тоо	300	400
3	Спортын цол, зэрэгтэй тамирчдын тоо	1.200	1.500
4	Стандартын шаардлага хангасан заалны тоо	25	28
5	Спортын холбоодын тоо	19	22
6	Улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцсон тамирчдын тоо	225	500
7	Улс, олон улсын чанартай уралдаан тэмцээнээс авсан медалийн тоо	243	500